

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ
/2025 оны жилийн эцсийн байдлаар/

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Үнэлгээ
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн									
3.3.	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	Хүүхдийн эрхийн индекс	оноо	2023	0.7 7.0	0.73 7.3	74.1	1/ Үндэсний Статистикийн Хорооны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал", маягтаар цуглуулж үр дүнг тооцож байна. -Хүүхэд хамгааллын үйлчилгээнд 117851 хүүхэд хамрагдсаныг 2024 оны байдлаарх 18 хүртэлх насны нийт хүүхдийн тоонд харьцуулж тооцсон. 18 хүртэлх насны нийт хүүхдэд эзлэх хувь -9,2% -Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт - 74.1 хувь байна. 2/ Хүүхдийн эрхийн индекс батлагдаагүй байгаа тул хууль эрх зүйн чадамжгүй үзүүлэлтээр үнэлэх боломжгүй. Нэмэлт тайлбар: Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг 2024 оны 1 дүгээр сард УИХ-аас баталсан Хүүхэд хамгааллын тухай хуультай /Шинэчилсэн найруулга/ нийцүүлэн шинэчлэх ажлыг 2025 оны 3 дугаар улирлаас эхлүүлж, хэрэгжилтийн болон өөрчлөлтийн дүн шинжилгээ хийж танилцуулах ажлыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт чиглэл болгосон. 2026 оны 1 дүгээр сард салбар дундын ажлыг хэсэг байгуулж ажиллахаар Үндэсний статиктикийн хороотой санал солилцсон. Мөн НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарсан уулзалт хийж, хүүхдийн эрх, хамгааллын 10 бүлгийн 169 үзүүлэлтийг хэлэлцэн сайжруулах үзүүлэлтүүдийг эхний байдлаар гаргасан.	70
3.4.	Нийгмийн баталгааг сайжруулна.	Төсвийн санхүүжүүлэх зардлын дотоодын нийт	Хувь	2023	3.6	3.3-аас бага буюу тэнцүү	2.8	2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн 80,663.1 тэрбум төгрөг байна. 2025 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 5 хувь гэж тооцоход	100

		бүтээгдэхүүнд эзлэх хувь						2025 оны дотоодын нийт бүтээгдэхүүн 84,696.2 тэрбум төгрөг болж байна. Үндэсний статистикийн хороо Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1,452.5 тэрбум төгрөгийг баталсан.. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ Нийгмийн халамжийн санд 2025 онд нийт 2,512.9 тэрбум төгрөг үүний, 1,564.7 тэрбум төгрөг хүүхдийн мөнгө, бусад 948.2 тэрбум төгрөг нь халамжийн мөнгө байна. Нийгмийн баталгааг сайжруулах зорилтод бүлэгт нийгмийн даатгалын санхүүжилт, халамжийн мөнгийг оруулан тооцоход нийт 2400.7 тэрбум төгрөг болж байна. Энэ нь 2025 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувь болох тооцоололтой байна.	
Хөтөлбөрийн үр дүн									
3.3.1.	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.	Хүүхэд хамгаалал шаардлагатай /зорилтот/ нийт хүүхдээс хувийн хэрэг нээсэн хүүхдийн эзлэх хувь - /кэйс шийдвэрлэлтийн хувь гэх	Хувь	2023	16.2	20	74.1	2025 оны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 36504 хүүхдэд хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлт гарган хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг бүрэн хүргэж, үр дүн гарсан 27082 хүүхдийн кейсийг хааж, шийдвэрлэлт 74.1 хувьтай байна. Хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлтийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үргэлжлүүлэн үзүүлж байгаа 9422 хүүхэд байна.	100
		Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь	Хувь	2023	33.9	35	37.0	- 21 аймаг, 9 дүүргийн газар, хэлтсүүдээр дамжуулан гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг 31 төв, танхимаар дамжуулан үзүүлж, 2025 оны 11 сарын байдлаар 97101 иргэн, үүнээс 55233 насанд хүрэгч, 39706 хүүхэд, 16335 хосод зөвлөгөө, мэдээлэл өгч, сэтгэл зүйн болон гэр бүлийн асуудлаарх хууль эрх зүйн зөвлөгөөг 59021 иргэнд өгч гэр бүлийн боловсрол олгох сургалтад 376433 иргэнийг хамруулсан. Давхардсан тоогоор <u>нийт өрхийн 37 хувьд гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчилгээ үзүүлсэн</u> байна.	100

3.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	Хувь	2023	30	60	53.8	Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Ховд аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв ажиллаж байгаа ба эдгээр аймгуудад нийт 23624 хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдардаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүд 2025 оны байдлаар давхардсан тоогоор 43,350 иргэнд үйлчилгээ үзүүлснээс 23,344 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 53.8 хувь нь төвөөр үйлчлүүлсэн байна. Тайлант хугацаанд үйлчилгээ авсан иргэдээс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах арга зүйн сургалтад нийт 3,344 хүн, ахмад настны өдөр тутмын үйл ажиллагаанд үнэлгээ хийх арга хэмжээнд 310 ахмад настан, дохионы хэлний сургалтад 272 хүн, олон нийтийн үйл ажиллагаанд 16,009 иргэн тус тус хамрагдсан байна.	90
3.4.1.	Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	Хувь	2023	23.78	8.0	6.0	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны бүх тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлэн олгосон. Энэхүү арга хэмжээний хүрээнд хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 572.4 мянган төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 859.5 мянган төгрөгт хүрсэн.	90
3.4.2.	Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ	Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл	Хувь	2023	0	6.0	6.0	Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон. Түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын нэмэлт хэлэлцээрийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	100

3.5.1.	Ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлнэ .	Хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин	Хувь	2022	58.6	60.3	62.7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөр”-г Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шинэчлэн баталж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн улсын хэмжээнд хэрэгжүүлдэг. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөрийг хэлэлцэж баталсан. Үүнд: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Түр ажлын байраар хангах болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа. ХЭҮЗ-ийн тогтоолыг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/50 дугаар тушаалаар хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа /хөтөлбөр/-ны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг, А/52 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг тус тус баталсан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийт 91,997 хүн хамрагдаж, 32,489 ажлын байраар хангагдсан байна. Мөн 2025 оны 03 дугаар улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 62.7 хувь байна.	100
Нийт 7 арга хэмжээний 8 шалгуур үзүүлэлт. Үүнээс: 100%-5, 90%-2, 70%-1.									93.8